



СҮХБААТАР АЙМГИЙН  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД  
АУДИТЫН АЛБА

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

2023 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 22

Баруун-Урт сум

Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын  
хөгжлийн газрын 2021-2022 оны  
санхүүгийн үйл ажиллагаанд хяналт  
шалгалт хийсэн тэмдэглэл

**Нэг. Шалгалтын зорилго**

Сүхбаатар аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны нэгдсэн удирдамжийн дагуу тус албаны даргын баталсан 2023 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн 21 тоот удирдамжийн хүрээнд аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оноос 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Шилэн дансны тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд үнэлэлт дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, мэргэжлийн туслалцаа үзүүлж, эрсдэлийн удирдлагаар хангахад шалгалтын зорилго чиглэгдлээ.

**Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн хугацаа:**

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор Д.Оюунсүрэн ахалж, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор Б.Чулуунбат, дотоод аудитор Л.Цэгмэд нар 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхэлж, ажлын 21 хоногт хийж гүйцэтгэлээ.

**Гурав. Шалгалтад хамрагдсан асуудлууд:**

Шалгалтад 2021, 2022 оны даргын тушаал, дотоод журам, санхүүгийн үндсэн баримтууд, тайлан тэнцлүүд, анхан шатны баримтууд хамрагдлаа.

**Дөрөв. Шалгалтад хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл:**

Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь Баруун-Урт сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрладаг, 1270001064 тоот улсын бүртгэлийн дугаартай, 9051716 тоот регистрийн дугаартай, Төрийн сангийн 100120017100,

нэмэлт санхүүжилтийн 100120017402 тоот төгрөгийн дансдуудтай, гэр бүл, хүүхэд залуучуудад төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд шуурхай, чанартай үзүүлж, тэдний оролцох, хамгаалуулах, хөгжих эрхийг хангаж, ээлтэй орчныг бүрдүүлэх зорилгоор удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 7, үйлчилгээний ажилтан 9, нийт 17 албан хаагчидтай ажилласан байна.

Тус байгууллагын шалгалтад хамрагдсан хугацааны харилцах данс, хөрөнгө мөнгө захиран зарцуулалтын байдлыг авч үзвэл: 1 дүгээр гарын үсгийг М.Туул /2021.01.01-2022.12.31/, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Индра /2021.01.01-2022.07.24, Ш.Хэрлэнтунгалаг 2022.07.25-2022.12.31/ нар зурж төсөв хөрөнгийг захиран зарцуулж ирсэн байна.

#### **Тав: Өмнөх шалгалтын талаар:**

1.Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 онд тус газрын 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж нийт 13887.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 1563.9 мянган төгрөгийн зөрчилд 2 салбар акт тогтоож, төсөв захирагч, эд хариуцагч нарт зөвлөмж өгснөөс 762.9 мянган төгрөгийн 1 актыг барагдуулж, 801.0 мянган төгрөгийн 1 актыг барагдуулаагүй, зөвлөмжийн биелэлтийг 80 хувь хангаж ажилласан байна.

2.Аймгийн Аудитын газраас 2022 онд 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж Зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна.

3.Аймгийн Аудитын газраас 2023 онд 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийж зөрчилгүй санал дүгнэлт өгч, төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэж буй албан хаагчдад цалин зөрүүтэй бодож олгосон 84.3 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн байна.

#### **Зургаа: Шалгалтын явцад хийгдсэн ажил, шийдвэрлэсэн асуудал:**

-Тухайн байгууллагын орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, төсөвт байгууллагын хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хийхэд:

Тус газар нь 2021 онд улсын төсвөөс 278,071.3 мянган төгрөгийн санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлого 38,933.3 мянган төгрөг, /Дээд шатны төсвийн захирагчаас 37,896.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого 1,036.8 мянган төгрөг/, орон нутгаас урсгал үйл ажиллагааны санхүүжилт 43,540.6 мянган төгрөг, нийт 345,330.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, 343,962.8 мянган төгрөгийн зарлага гаргаж 1,367.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж ажилласан байна.

2022 онд улсын төсвөөс 522,751.6 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар 33,089.5 мянган өгрөг /дээд шатны төсөв захирагчаас 26,519.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого 6,569.8 мянган төгрөг/, нийт 555,841.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, 525,434.3 мянган төгрөгийн зардал гарган 30,406.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж ажилласан байна.

Төсвийн зарцуулалтын талаар:

2021 оны төсөвт зардлын гүйцэтгэлээр: үндсэн цалин болон нэмэгдэл урамшил 162,686.7 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 21,552.2 мянган төгрөг, байр ашиглалтын тогтмол зардал 24,022.7 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 15,334.8 мянган төгрөг, нормативт зардал 5007.8 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 16,135.9 мянган төгрөг, томилолтын зардалд 693.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 79,985.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 11,635.1 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг /нэг удаагийн тэтгэмж урамшуулал 6,163.0 мянган төгрөг, төвлөрүүлэг шилжүүлэг 1,367.2 мянган төгрөгийн тус тус зардал гаргаж ажилласан байна.

2022 онд төсөвт зардлын гүйцэтгэлээр: үндсэн цалин болон нэмэгдэл урамшил 237,436.9 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 28,500.4 мянган төгрөг, байр ашиглалтын тогтмол зардал 25,372.1 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 1,792.1 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 7,176.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 147,276.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 2,222.0 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 42,324.9 мянган төгрөгийг тус тус зарцуулж ажилласан байна.

Нэмэлт санхүүжилтийн талаар:

2021 онд нэмэлт санхүүжилтийн нийт 38,933.3 мянган төгрөгийг нийгмийн бүлэг рүү чиглэсэн хөтөлбөр үйл ажиллагаа, хамгаалах байрны стандартыг хангахад зарцуулсан.

2022 онд хоол хүнсний зардалд 3,192.8 мянган төгрөг, тавилга худалдан авахад 2,089.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 25,624.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 2,176.8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

-Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд бүрэн тусгасан эсэх:

Тус байгууллага нь 2022 онд ажиллагсадтай холбоотой авлага 972.6 мянган төгрөг, байгууллагаас авах 1,485.4 мянган төгрөг, нийт 2,458.0 мянган төгрөгийн авлагын эхний үлдэгдлийг, мөн богино хугацаат 966.3 мянган төгрөгийн өглөгийн эхний үлдэгдлийг тус тус барагдуулан ажиллаж, 2022 оны жилийн эцсээр авлага, өглөггүй ажилласан байна.

-Үндсэн ба эргэлтийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, зарцуулалтын байдал, тооллого үнэн зөв чанартай хийгдсэн эсэх:

/ Мянган төгрөгөөр /

	Балансын зүйл	2021 он			2022 он		
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
1	Барилга/байгууламж	179,733.9	179,733.9	0	179,733.9	179,733.9	-
2	Тоног төхөөрөмж	35,813.8	48,078.0	12,264.2	48,078.0	61,451.6	13,373.6
3	Авто тээврийн /х	21,437.5	21,437.5	0	21,437.5	21,437.5	-
4	Тавилга эд хогши л	42,512.6	46,828.9	4,316.3	46,828.9	46,828.9	-
5	Программ хангамж	675.0	675.0	0	675.0	875.9	201.0
6	Бусад үндсэн хөрөнгө	30,840.0	30,840.0	0	30,840.0	30,840.0	-
	ДҮН	311,012.8	327,593.3	0	327,593.2	311,012.8	13,574.6

2021 онд төсвийн хөрөнгөөр 15,215.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдаж авсныг,

2022 оны Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 13,373.6 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж / 2ш зөөврийн компьютер, зургийн аппарат 1ш, принтер, хуруу уншигч г.м/, мөн 201.0 мянган төгрөгийн вирусийн программыг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд орлогоор тусгасан байна. Тус онд хөрөнгө актлаагүй байна.

*Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаандаа хийсэн дотоод хяналт, шалгалт, түүний төлөвлөгөө, гүйцэтгэл, гарсан үр дүн, тайлагналын байдалд хяналт шалгалт хийхэд:*

Газрын даргын даргын 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/98 тоот тушаалаар дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг баталж, 2022 оны 06 сарын 13-ны өдрийн Б/45 тоот тушаалаар дотоод хяналтын нэгжийг шинэчлэн байгуулсан байна.

2021 онд дотоод хяналт шалгалтыг 3-н чиглэлээр 11-н ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөн хэрэгжүүлсэн, 2022 онд 7-н ажлыг хийж гүйцэтгэхээр

төлөвлөснөөс 6-н ажлыг хэрэгжүүлэн ажилласан байна. Шалгалтыг төлөвлөгөөний дагуу удирдамж батлуулан гүйцэтгэж илтгэх хуудсаар тайлагнан ажилласан байна. Шалгалтын удирдамж болон тайланд өмнөх шалгалтын хэрэгжилтийн талаар тусгаагүй, мөн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаагүй байна.

Иймээс дотоод хяналт шалгалтыг тухайн жилийн дэвшүүлсэн зорилго, зорилт болон эрсдэлд суурилан төлөвлөх, хяналт шалгалтын давтамжийг эрсдэлтэй байдалд тулгуурлан тогтоож өгөх. Түүнчлэн хяналт шалгалтыг хийхдээ удирдамж, ажлын төлөвлөгөө гаргах, түүний дагуу хяналт шалгалтыг хийж илэрсэн асуудлын шалтгаан нөхцөлийг тогтоож, түүнийг арилгах талаар зөвлөмж өгөх, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тайланд тусгаж хяналт шалгалтын төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүрч ажиллах шаардлагатай байна.

***Мэдээллийн ил тод байдлын талаар:***

Тус байгууллагын ил тод байдлын самбарт сарын мэдээ, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, санхүүтэй холбоотой хууль, журам зэргийг байршуулсан байна.

Шилэн дансны цахим хуудсанд 2021 онд 151 мэдээлэл оруулахаас 135 мэдээллийг хуулийн хугацаанд нь мэдээлж 16 мэдээллийн хугацааг хоцроосон, 2021 оны гүйцэтгэл 100 хувьтай байна. 2022 онд 151 мэдээлэл оруулахаас 149 мэдээллийг хуулийн хугацаанд нь мэдээлж 2 мэдээллийн хугацааг хоцроосон, 2022 оны гүйцэтгэл 100 хувьтай байна.

***Долоо: Шалгуулагчийн ололттой, дэвшилттэй тал:***

Тус газар нь 2021, 2022 онуудад аймаг, нийслэлийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, түүний үнэлгээгээр 90 хувиас дээш үнэлэгдэж улсын хэмжээнд хоёр жил дараалан гуравдугаар байр эзэлж, 2022 онд аймгийн хяналт шинжилгээ, үнэлгээний үнэлгээгээр аймагтаа нэгдүгээр байранд тус тус шалгарсан байна.

Санхүүгийн үйл ажиллагааг ил тод нээлттэй ажиллуулж Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу санхүүгийн тайлан, бүртгэлээ нягтлан бодох бүртгэлийн бодлого, аргачлал, журмын дагуу хийж гүйцэтгэн ажилласан ололттой талууд байна.

**Найм: Шалгалтаар илрүүлсэн нийтлэг зөрчил, дутагдал, шалтгаан түүнээс гарч болзошгүй буюу гарсан хохирол, хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилт:**

1. Тус газрын даргын 2021.07.28-ны өдрийн А/82 тоот тушаалаар Монгол Улсад ахмадын байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний “Ахмад-90” дуу, шүлгийн цахим анхдугаар уралдааныг хамтран зохион байгуулахад зориулж 500.0 мянган төгрөгийн хандивийг нийгмийн бүлэгт зориулсан хөтөлбөр арга хэмжээний зардлаас зарцуулсан, мөн газрын даргын 2021.09.27-ны өдрийн А/94 тоот тушаалаар Залуучуудын байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд шинээр байгуулагдсан “Залуус хөгжлийн төв”-ийг 336.5 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж /зөөврийн өсгөгч/ авч өгч дэмжлэг үзүүлсэн зэрэг нь Төсвийн тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 25 дугаар зүйлийн 25.10-д “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэж заасантай;

2. Тус газар нь 2021, 2022 онд тараах материал, гарын авлага хэвлүүлэхэд 26,779.0 мянган төгрөг, 2022 оны үйл ажиллагааны тайланг хэвлүүлэхэд 226.0 мянган төгрөг, 2022 онд сургалт зохион байгуулахад цай, хоолны зардалд 3934.0 мянган төгрөг, нийт 30,939.0 мянган төгрөгийн төсвийг хэмнэлттэй зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тушаалын 1.7-д “хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх” гэж заасантай;

3. Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны 03 сарын 04-ний өдрийн “Сургалт зохион байгуулах тухай” А/24 тоот тушаалаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7.14 дэх заалтын дагуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын эмэгтэй албан хаагчдад төсвөөс 420.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар

төлөвлөж, зарцуулах”, мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6-д “ Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын тэмцээн, салбарын алдар, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх” гэж заасантай;

4.Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны 05 сарын 25-ны өдрийн “Хөрөнгө зарцуулах тухай” А/46 тоот тушаалаар хүүхдийн хөгжил хамгааллын урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас байгууллагын ажилтан, албан хаагчдын хүүхдүүдийн гарын бэлэгт 629.4 мянган төгрөг, мөн 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Хөрөнгө зарцуулах тухай” А/105 тоот тушаалаар хүүхэд хөгжил хамгаалал, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардлаас ажилчдын хүүхдүүдэд дархлаажуулалтад 1,020.0 мянган төгрөг, нийт 1,649.4 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” 190 дүгээр тушаалтай тус тус нийцэхгүй байна.

**Ес: Авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө өгсөн байдал:**

Тус байгууллагын дарга, нягтлан бодогч нарт шалгалтын удирдамжийг танилцуулж, санхүүгийн баримтуудыг хүлээн авч шалгалтыг эхэллээ. Шалгалтын явцад газрын дарга, нягтлан бодогч, нярав, дотоод ажил хариуцсан ажилтан болон холбогдох хүмүүстэй уулзаж тодруулга авч, шалгалтаар гарч байгаа зөрчил дутагдлыг танилцуулж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа. Мөн төсвийн орлого зарлагыг төлөвлөх, үндсэн үйл ажиллагаанд чиглэсэн хөтөлбөрийн зардлын төлөвлөлтийг хэрхэн боловсруулах талаар санал солилцож мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8 дахь хэсэгт “хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг өгч биелэлтийг хангуулах” гэснийг үндэслэн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, таслан зогсоох зорилгоор шалгалтаар нийт 33,844.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 27,005.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 6,839.9 мянган төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн 5-н заалттай хугацаатай 1 албан шаардлага үйлдэж шийдвэрлэв.

**Арав: Шалгагдсан аж ахуйн нэгжид өгсөн дүгнэлт, шийдвэрлэвэл зохих асуудал:**

Сүхбаатар аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, анхан шатны баримтын бүрдэл, санхүүгийн тайлан тэнцлийн гаргалтын байдал сайн байгаа хэдий ч шалгалтаар илэрсэн асуудлын 95.0 хувь нь төсвийг хэмнэлтгүй, төлөвлөлтгүй зарцуулсан зөрчил эзэлж байна. Энэ нь төсвийг эдийн засгийн ангилал, хөтөлбөр, зориулалт тус бүрээр үйл ажиллагааны чиглэл нэг бүртэй уялдуулан төлөвлөх, зарцуулах журамгүй байгаатай холбоотой гэж үзэж байна. Мөн шалгалтад хамрагдсан онуудад нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн болон хүүхэд хамгааллын зардлын төсөв нийт 248503.4 мянган төгрөг батлагдсанаас Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 01 сарын 31-ний өдрийн "Аргачлал, зардлын норматив батлах тухай" А/23/27 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу 45.6 хувийг зарцуулж, үлдэх 54.4 хувийг ямар нэгэн журамгүй зарцуулсан байна.

Иймд үндсэн үйл ажиллагааны зардал болон нийгмийн бүлэгт чиглэсэн арга хэмжээ, хүүхэд хамгааллын зардлын төсвийг үр ашигтай, хэмнэлтэй байхаар төлөвлөн зарцуулж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, нийгмийн баталгааны хөтөлбөр зэрэг нийгмийн асуудалд чиглэсэн зардлуудыг үндсэн үйл ажиллагааны зардлын төсөвт төлөвлөж, хөтөлбөр, зориулалтын бусад зардлыг үндсэн үйл ажиллагааны зардалд зарцуулагдахгүй байхаар зохицуулалт хийн тус зардлын төлөвлөлт, зарцуулалт, тайлагналтыг журмаар зохицуулах. Түүнчлэн тараах материал, гарын авлагыг өөрөө хэвлэж, шагнал урамшуулал өргөмжлөл, өмгөөллийн үйлчилгээнд улсын өмгөөлөгчийг татан оролцуулах зэргээр төсөв, зардлаа хэмнэж ажиллах шаардлагатай байна гэж дүгнэлээ.

**Арван нэг. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж  
Төсвийн ерөнхийлөн захирагчид:**

1. Төсвийг үр дүнтэй зарцуулах зорилгоор хүүхэд хөгжил хамгааллын зардал болон нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр арга хэмжээний зардлыг захиран зарцуулах, тайлагнах журмыг боловсруулан батлуулах;

2. Төсвийн шууд захирагчийн үндсэн үйл ажиллагааны зардлыг батлахдаа албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, сайжруулах зорилгоор хөдөлмөрийн дотоод журамд тусгагдсан зардлуудыг үндсэн үйл ажиллагааны зардалд тусгаж өгдөг байх.

**Төсвийн шууд захирагчид:**



1. Төсвийг хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал нэг бүрээр үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах;

2. Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбогдуулан төсвийг хэмнэх талаар дорвитой арга хэмжээг зохион байгуулж, танхимийн сургалт, хэвлэл, тараах материал, өмгөөллийн хөлс зэрэг зардлуудыг хэмнэх;

3. Байгууллагын даргын нэрэмжит аливаа шагнал, урамшууллын зардлыг гаргахгүй байхад анхаарч хүүхдийн эрхийг хангахад дэмжлэг үзүүлж, амжилт гаргасан хуулийн этгээдийг алдаршуулах, шагнаж урамшуулахад анхаарч ажиллах.

Танай байгууллагад хийсэн хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар хүргүүлж буй энэхүү зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэсэн арга хэмжээг албан бичгээр 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд ирүүлэх, шалгалтаар илэрсэн зөрчилд дүгнэлт хийж арилгах, давтан гаргахгүй байх.


#### ТАНИЛЦУУЛГА ҮЙЛДСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ, ДОТООД АУДИТОР  Д.ОЮУНСҮРЭН

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ, ДОТООД АУДИТОР  Б.ЧУЛУУНБАТ

ДОТООД АУДИТОР  Л.ЦЭГМЭД

#### ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН АВСАН:

АЙМГИЙН ГЭР БҮЛ ХҮҮХЭД ХӨГЖИЛ  
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА  М.ТУУЛ

НЯГТЛАН БОДОГЧ  Ш.ХЭРЛЭНТУНГАЛАГ

